

ГАЛ ТҮЙМРИЙН ХЯНАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТУЛГАМДАЖ БҮЙ ЗАРИМ АСУУДАЛ

SOME ISSUES ON REVIEWING OF FIRE FIGHTENING



Х.СҮХБААТАР

ХСИС-ийн Онцгой байдлын сургуулийн Гамшгаас хамгаалах албаны тэнхимийн дэд профессор, онцгой байдлын хошууч

SUKHBAATAR KH.

Assistant professor, Disaster Department, Emergency Management School, Law Enforcement University, Major

Товч агуулга: АМонгол улсын эдийн засаг сүүлийн жилүүдэд эрчимтэй хөгжих хандлага бий болж, өндөр барилга, үйлдвэр, уул уурхай, барилга байгууламж олноор баригдаж, хот суурин газарт хүн амын төвлөрөл нэмэгдэж байна.

Энэ бүхнийг дагаад гамшиг осол, гал түймрийн тоо, хохирол өсөн нэмэгдэх хандлагатай байгааг сүүлийн 5 жилийн байдал тухайлбал Улаанбаатар хотод гарч байгаа гал түймрийн тоо жилд дунджаар 12-15 хувиар нэмэгдэж байгаа баримт харуулж байна.

Abstract: Psychological, physical and skill training of rescuers and firefighters is a crucial to perform rescue and firefighting operations rationally, intelligently and efficiently. This training depending upon many factors, is a complex process with many components. This research studies the characteristics and requirements of psychological, physical and professional skills training and as well as the ways of training-preparation and shows their effect for the rescue and firefighting operations.

Монгол улсын Үндсэн хуульд заасан Монгол улсын иргэний аюулгүй амьдрах эрхийг хангах талаар төрийн хүлээх үүргийн нэг болсон гамшиг осол, гал түймрийн болзошгүй аюулаас ард иргэдийн амь бие, эд хөрөнгийг хамгаалах, урьдчилан сэргийлэх зорилгоор аюулгүй байдлыг хангуулах шаардлага зүй ёсоор тавигддаг.

Монгол улсын эдийн засаг сүүлийн жилүүдэд эрчимтэй хөгжих хандлага бий болж, өндөр барилга, үйлдвэр, уул уурхай, барилга байгууламж олноор баригдаж, хот суурин газарт хүн амын төвлөрөл нэмэгдэж байна.

Энэ бүхнийг дагаад гамшиг осол, гал түймрийн тоо, хохирол өсөн нэмэгдэх хандлагатай байгааг сүүлийн 5 жилийн байдал тухайлбал Улаанбаатар хотод гарч байгаа гал түймрийн тоо жилд дунджаар 12-15 хувиар нэмэгдэж байгаа баримт харуулж байна.

Өнөөгийн энэ нөхцөл байдал ард иргэдийн аюулгүй байдлыг хангуулах хууль тогтоомж, дүрэм норм, стандартыг улам боловсронгуй болгож, хүчин чадлыг

нэмэгдүүлэх, түүний хэрэгжилтийг хангуулахад илүү анхаарах шаардлагатай байна.

Дэлхийн уур амьсгалын өөрчлөлт, улс орны нийгэм, эдийн засгийн хөгжил дэвшил, хотжилт, хүн амын нягтрал, барилгажилт, өндөр барилга байгууламж, үйлдвэржилт, уул уурхайн техник технологийн хөгжил, ядуурал зэрэгтэй холбогдон гамшиг осол, гал түймрийн эрсдэл жил тутам өсөн нэмэгдэж байна. Зөвхөн сүүлийн 3 жилд объектын гал түймэр **9105** удаа гарч төр, аж ахуйн нэгж байгууллага, иргэдийн өмчинд **18,7 тэрбум** төгрөгний хохирол учирч, гал түймрийн улмаас **224** хүн амь насаа алдаж, **155** хүн түлэгдэж гэмтэн, **2298** барилга, орон байр, гэр галтүймэрт өртөн шатсан байна. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын аюулгүй байдлыг хангуулах талаархи эрх зүйн орчинг боловсронгуй болгожгамшиг осол, гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг оновчтой зохион байгуулах шаардлага бидний өмнө бий болоод байна.

Улсын хэмжээнд гамшиг, гал түймрийн хяналтын ажлыг Гамшгаас хамгаалах тухай, Галын аюулгүй байдлын тухай, Захиргааны хариуцлагын тухай хууль, Засгийн газрын 1999 оны 209, 2006 оны 105 дугаар тогтоол, /Гал түймрийн улсын хяналтын дүрэм, Гамшгаас хамгаалах улсын хяналтын дүрэм/ ОБАЭС-ын 2006 оны 52 дугаар тушаалын хүрээнд аж ахуй нэгж, байгууллага, ард иргэдэд гамшиг болон галын аюулаас урьдчилан сэргийлэх хяналт шалгалтуудыг зохион явуулж байна.

Одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа дээрх хууль тогтоомж, дүрэм нь өнөөгийн нөхцөлд хяналтын эрх зүйн орчинг бүрдүүлж чадахгүй байна. Цаашид бидний дагаж мөрдөж байгаа хууль тогтоомжууд болон дүрэм журам, норм стандартуудыг орчин үеийн шаардлагад нийцүүлэн дахин боловсруулж бүх нийтээр дагаж мөрдүүлэх шаардлагатай. Энэхүү эрх зүйн орчинг сайжруулж өгснөөр гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх, хяналтын ажлыг бүрэн утгаар нь явуулах эрх зүйн орчин бүрдэнэ.

Улсын хэмжээнд хяналтын чиглэлээр нийт 116 албан хаагч ажиллаж байна. Үүнээс Гал түймрийн улсын хяналтын байцаагч-27 /нийслэлд/, Гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч-89 / орон нутагт/ ажиллаж байна.

ОБЕГ-ын Гал түймэртэй тэмцэх газрын Хяналтын хэлтэс нь 21 аймагт хяналтын тасагтайгаар үйл ажиллагаа явуулж байна.

1-р бүсэд 4-5 байцаагчийн орон тоотойгоор явуулж байгаа боловч нийслэлийн дүүргүүдийн Онцгой байдлын хэлтсүүдэд гамшгийн хяналтын байцаагчтай нийлээд 3 алба хаагч хяналт шалгалтыг явуулж байгаа нь нийт аж ахуй нэгж, байгууллагад хяналт шалгалтыг явуулахад нэг хүнд ноогдох ажлын ачаалал их байна. Тийм учраас дүүргүүдэд хяналтын тасагтай болгож байцаагчийн орон тоог нэмэх шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Хяналтын болон урьдчилан сэргийлэх чиглэлээр ажиллаж байгаа алба хаагчдын тоо болон зарцуулж байгаа төсөв харьцангуй бага байна. Онцгой байдлын байгууллагын хэмжээнд зарцуулах төсөвт урьдчилан сэргийлэх чиглэлээр зарцуулах төсвийг 20%-д, хяналтын байцаагч нарын тоог 20%-д хүргэж ажиллуулснаар нийт байцаагч нарын ажлын ачаалал багасаж аж ахуй нэгж, байгууллагуудад тавих хяналт шалгалтын ажил сайжирна.

Гамшиг, гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх хийгдэж байгаа ажил нь зөвхөн нэг байгууллагын, нэг газар, хэлтсийн ажил биш тул түүнээс урьдчилан сэргийлэх мэдээлэл, сурталчилгааны үндэсний хөтөлбөр боловсруулснаар энэ чиглэлээр бүх шатны байгууллага, иргэдийн хүлээх үүрэг тодорхой болж түүнийг

дагаж төсөв хөрөнгө нь шийдэгдсэнээр гал түймрийн тоо хохирол буурна.

Гал түймрийн хяналт шалгалтыг хөнгөвчлөхийн тулд хороо, багт урьдчилан сэргийлэх, тусламж үзүүлэх төв байгуулж тус төвд ажиллаж байгаа ажилчид хороо, багаар үйлчлүүлж байгаа ард иргэдэд гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх талаар сургалт сурталчилгааг зохион байгуулах боломж нь бүрдэж өгнө.

Онцгой байдлын байгууллагын хэрэгжүүлэх чиг үүргээс төрийн бус байгууллагад зарим нэг чиг үүргийн шилжүүлэн хэрэгжүүлэх. Жишээ нь: /Улсын хэмжээнд бүх аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд гамшиг, гал түймрээс хамгаалах, урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгааны ажил явуулах/

Гал түймэр ихээхэн гарч байгаа гэр хорооллын хороодын судалгааг үндэслэн хяналт шалгалт явуулах хуваарь гаргаж нэгдсэн байдлаар шалгалт явуулах, иргэдийн идэвхийг өрнүүлэх, анхаарлыг татах арга хэмжээ зохион явуулах нь гал түймрийн тоо хохирлыг бууруулах шндэс болох бөгөөд гал унтраах ангийн бие бүрэлдэхүүн айл өрхөд галын аюулаас урьдчилан сэргийлэх үзлэг хийж илэрсэн зөрчлийг хариуцсан байцаагчид мэдэгдэн ажиллаж байгаа боловч гал сөнөөгч айл өрхөд нэвтрэн орох хууль эрх зүйн орчин байхгүй байгаа нь учир дутагдалтай байна.

Гал түймэр их гарч байгаа гэр хорооллын хороодын судалгааг үндэслэн урьдчилан сэргийлэх өдөрлөг, хяналт шалгалт явуулах хуваарь гаргаж хяналт шалгалт явуулж, хөдөлгөөнт машинт ухуулга сурталчилгааг хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй уялдуулан өдөр тутам зохион байгуулах нь иргэдийн аюулгүй байдлыг хангах нэг чухал үзүүлэлт болно.

Олон хүн үйлчлүүлдэг газруудад телевизийн сэрэмжлүүлэг, заавар, зөвлөгөөг өгөх бичлэгийг холбогдох өгч, тэдгээрт хяналт тавьж ажиллах хэрэгтэй байна.

Сургуулийн өмнөх болон, ЕБС-ийн сурагчдад гамшиг осол, гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх сургалтыг тусгай хөтөлбөр боловсруулан шат дараалсан сургалтуудыг зохион байгуулах нь хүүхэд багачуудыг багаас нь гал түймрээс урьдчилан сэргийлэх, гарсны дараа өөрийгөө хамгаалах чадвар чадамжтай болох эхлэл тавигдана.

Дүгнэлт

Гамшиг, гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх болон хяналт шалгалтыг байцаагч бүр иргэд болон аж ахуй нэгж, байгууллагад ойлгомжтой, шаардлагын тогтолцоо бий болгох үүднээс аж ахуй нэгж байгууллагуудын гал, хөдөлмөр хамгаалал хариуцсан ажилтнаар бөглүүлдэг хяналт шалгалтын хуудас бий болгох ингэснээр Гал түймрийн улсын хяналтын байцаагчдийн ажлын ачаалал буурах, аж ахуй нэгж байгууллагын ажилтан, албан хаагчид өөрсдөө аюулгүй байдлаа хангах үндэс нь бий болж өгнө.

Даатгалын тухай хуулинд нэмэлт өөрчлөлт оруулж галын аюулаас хамгаалах заавал даатгалын систем бий болгож төр, аж ахуй нэгж, байгууллага, ард иргэд өөрсдийн өмч хөрөнгийг заавал даатгуулснаар гал түймэр гарсан тохиолдолд өөрсдийн хохирлыг нөхөн төлүүлэх нөхцөл боломж нь бүрдэж өгнө.

Аж ахуйн нэгж, байгууллагуудын гал, хөдөлмөр хамгаалал хариуцсан ажилтныг Хууль сахиулахын их сургууль болон Онцгой байдлын ерөнхий газарт гамшиг, гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх тусгай сургалтанд хамруулж, тухайн байгууллагын аюулгүй байдалд хяналт тавьж илэрсэн зөрчил дутагдлыг тухай бүрд нь арилгснаар гал түймэр гарах нөхцөл байдлыг таслан зогсоох боломж

бүрдэж өгнө.

Эх сурвалжийн жагсаалт

1. Гамшгаас хамгаалах тухай хууль 2003 он
2. Галын аюулгүй байдлын тухай хууль 1999 он
3. Гамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлого 2011 он
4. Гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагчийн дүрэм 2005 он
5. Гал түймрийн улсын хяналтын байцаагчийн дүрэм 1999 он
6. Гамшиг осол, гал түймрийн статистик тоо мэдээ 2013 он